

ДҮРВЭГСДИЙН АСУУДАЛ МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХОЛБОГДОХ НЬ

МУИС, ОУХС-ийн магистр
Л.Гүвшинцэнгэл

Даяаршлын үйл явц улам бүр гүнзгийрч, дэлхийн улс гүрнүүд олон талт нээлттэй гадаад бодлого явуулах таатай орчин бүрдэж буй нь өнөөгийн олон улсын харилцааны чиг хандлага болж байна. Гэвч эл үйл явцад улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг үзэгдэл, үр дагавар гарсаар байгааг үгүйсгэх аргагүй юм.

Арьсны өнгө, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, нийгмийг хамарсан зөрчил, түүнчлэн овог аймгийн мөргөлдөөн, дайн дажин, террорист ажиллагааны улмаас харъяат улсынхаа нутагт аж төрөх боломжгүй болсон дүрвэгсдийн асуудал олон улсын байгууллагууд, улс гүрнүүдийн анхаарлыг татсаар байна. Учир нь дайн байлдаан, мөрдлөг хавчлага буюу хүний эрх нь ноцтой зөрчигдсөн бусад шалтгаанаар дайжиж өөр улсаас өмгөөлөл, ивээл эрэлхийлэн аргагүйн эрхэнд уугуул нутгаасаа дайжигсдын тоо жил ирэх тутам нэмэгдэж орох оронгүй, зовлон зүдгүүр амсаж яваа гэмгүй олон хүн зоны амьдрах орчин тэдний ирээдүй эмгэнэлтэй байдалд хүрээд байна.

Ийм ч учраас дэлхийн хамтын нийгэмлэг НҮБ-аас дүрвэгсдийн асуудлаар тусгай шийдвэр гаргаж, тэдэнд орогнох эрх олгох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх талаар нэлээд ажил зохиож, төр, засгийн анхаарлыг дүрвэгсдийн асуудалд хандуулахыг улс гүрнүүдэд уриалсаар байгаа юм. Тухайлбал: НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд Комиссарын газраас 2000 оны 5 дугаар сард, 2001 оны 7 дугаар сард тус тус Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын ДДК-ын Бээжин дэх бүсийн Төлөөлөгчийн газрын хооронд Харилцан ойлголцох санамж бичигт гарын үсэг зурж, тус оронд төлөөлөгчөө ажиллуулах тохиролцоонд хүрч, Монголын төрийн албан хаагчид хийгээд Хилийн Цэргийн Удирдах Газартай хамтран сургалт семинарыг тус тус зохион байгуулсан зэргээс үзэхүл Олон улсын байгууллагаас дээрх асуудалд анхаарлаа хандуулахыг уриалж багагүй ажил хийсэн боловч энэ талаархи манай Засгийн газар, холбогдох байгууллагуудын эрх зүйн нэгдсэн бодлого, зохион байгуулалттай үйл ажиллагаа илт үгүйлэгдэж байна.

1950 онд НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд Комиссар (ДДК)-ын газар байгуулагдах үед Дэлхийн II дугаар дайны уршгаар 1,2 сая орчим хүн уугуул нутгаа орхин дүрвэж байсан бол эдүгээ 22,3 сая¹ гаруй дүрвэгсэд байгаагийн ихэнхийг хүүхэд, эмэгтэйчүүд эзэлж байгаа нь дэлхий нийтийн анхаарлыг зүй ёсоор татсан асуудал болоод байгаа юм.

Дүрвэгсдийн асуудал ОУБ, улс гүрнүүдийн анхааралд байх тулгамдсан асуудал болоод байгаа өнөө үед Монгол улсын геополитикийн

¹ НҮБ-ын ДДК Рүүд Любберсийн 2001 оны Ерөнхий Ассемблейн чуулганд хэлсэн үгнээс...

орчинтой уялдан ирээдүйд гарч болох дүрвэлт, олноор нүүдэллэх, чөлөөт урсгал зэрэг янз бүрийн үзэгдэлд төрийн холч мэргэн бодлогын хүрээнд "асуудлыг болохоос нь өмнө" болзошгүй зүйлд бэлэн байх гэдэг утгаараа хэтийн төлөв байдлыг харсан хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

1990-ээд оны дунд үеэс Монгол Улсын нутгаар дамжин Өмнөд Солонгос руу дүрвэж буй Умард Солонгосчуудын урсгал нэлээд нэмэгдэх хандлага ажиглагдаж байгааг холбогдох албан тушаалтнууд тэмдэглэж байна. Үүнд БНАСАУ, манай хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хийгээд нэгэн үзэл суртлаар хүмүүжиж ирсэн ч нөлөөлсөн талтай. 1999-2001.11 дүгээр сар хүртэлх мэдээгээр үзэхэд 1999 онд 9 удаагийн 28 хүн, 2000 онд 14 удаагийн үйлдлээр 60 хүн, 2001 оны 11 дүгээр сарын 1-ний байдлаар 36 удаагийн үйлдлээр 142 хүн Дорнод, Дорноговийн нутгаар хилийн боомтгүй газраар ямар ч бичиг баримтгүй орж ирж байгааг манай улсын дээрх асуудлыг хамаарах байгууллагууд "хилийн зөрчил" гэдэг байдлаар хандаж байгаатай санал нийлэхгүй байна.

Учир нь олон жил өлсгөлөн нүүрлэсэн, жил дараалан ган гачиг болж буйн улмаас ургац алдаж улмаар нэг намын явцуу үзэл сурталд баригдсан, нэг хүнийг бурханчлан тахин шүтдэг "сталинчлах" үзэл баримтлал хэвээр ноёрхсоор байгаа зэрэг нь тэдгээр хүмүүсийг дүрвэхэд хүргэж байгаа гол шалтгаан гэж үзэж байна. Умард солонгосоос дүрвэгсдийг тэд "умардаас оргогсод буюу зугтаагсад" гэж томъёолж байгаа бөгөөд солонгосоор "таль бүг жа" гэж хэлдэг аж. Умард Солонгосоос Өмнөд Солонгос руу зугтахын тулд ганц Монголын нутгаар тогтохгүй Гонконг, Индонез, Тайланд, Филиппин, Макао-гоор дамждаг байна.

Харин Монгол руу нэвтрэн орж ирэхийн тулд Хятадын хойд муж болох Хэ лүн жянь, Чигикар, Жилин, Мугдэн зэрэг мужуудаар өнгөрдөг бөгөөд тэдгээр мужуудад XVI зууны орчим /Манжийн хааны үе/-д шилжин суурьшсан солонгос гаралтай 3-3,5 сая хүмүүсийн тусламжтай Хятадын өргөн уудам нутгаар нуугдан гарч ирдэг байна.

Монгол улс нэг бус удаа дайны уршгаар өнчирч үлдсэн дүрвэгч хүүхдүүдийг ивээлдээ авч байсан түүхэн туршлага бий. Тухайлбал: 1952-1959 онуудад Солонгосын дайны үед эцэг, эх нь амь үрэгдсэн, өнчин үлдсэн 197 хүүхдүүдийг 8 багшийн хамт Улаанбаатар хотноо авчран асран хүмүүжүүлж 30 гаран оюутныг өөрийн их, дээд сургуулиудад сургаж, дээд боловсрол эзэмшүүлэн цаг тайван болсны дараа эх нутагт нь буцааж байсан болно. Хэдийгээр тэр үед манай улсын эдийн засгийн хүчин чадал тийм ч сайн байгаагүй боловч тухайн үеийн ханшаар 8 сая 544 мянга 400 төгрөгийн зардал гарган өвөлд нь Зайсан толгойн аманд зунд нь Шарга морьтын аманд тусгайд нь сургууль, дотуур байр, сурч боловсрох, амьдрах нөхцлөөр хангаж өгч байжээ.

Дараагийн нэг жишээ бол 1979 онд ЗХУ, Афганистаны хоорондын дайны уршгаар өнчин үлдсэн 20-иод афган хүүхдүүдийг Монголд асран хамгаалж байгаад буцааж байжээ.

XX зууны эхэн үед Монголд дүрвэн ирсэн казах, буриадуудын асуудлыг сөхье. 1910-1920 оны үед Монголын хүн амын байршил, шилжих

хэд
эдий
дүр

гэдэ
боло
була
дага
Оро
зэрэ
оло
сума
орчм
байн

дара
туур
урил

иргэ
гарц
цага
эрэл
дүрв
Баян
Цага
анхд
харь

Шин
Ховд
өргө
хаан
үед н

хэрхэ
үгүй
дүрвэ
хүлээ

² Роберт

³ "Орос

⁴ Д.Дам

⁵ Д.Дам

⁶ Төрийн

хөдөлгөөнд нэлээд өөрчлөлт гарсан нь хойд их хөрш улсад гарсан нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үр дүнд олон мянган буриад, казахууд дүрвэн, цагаачлан, шилжин суурьшсан явдал байв.

Буриадууд XX зууны эхээр нийтдээ 3 шаттай Монголд дүрвэн оржээ. Үүнд:

1. 1904-1905 он. Цагаан хаант Оросын Засгийн газар "харь гаралтан" гэдэг онцгой байдлыг эцэс болгон буриадуудыг цэргийн албанд татах болсон. Мөн Өвөр Байгалийн хошууны буриадын уламжлалт газрыг ихээр булаан авч, Орос, Украйны тариачдад хуваан өгч эхэлсэн, Сибирийг дагасан төмөр зам тавьсны нөлөөгөөр Орос-Японы дайнд ялагдсан Оросууд буриадын нутгаар дайран өнгөрөхдөө буриад зоныг түйвээсэн зэрэг нь тэдний дургүйцлийг улам нэмэгдүүлсэн байна². Үүний улмаас олон айл дүрвэж 1902 онд одоогийн Дорнод аймгийн Чулуунхороот сумаар 700 илүү өрх айл, 1903 онд одоогийн Хэнтий аймгийн Дадал сумын орчмоор 35 хүн ам бүхий хориод өрх, нэлээд малтай хойноос нэмж ирсэн байна³.

2. 1910-1912 он. Энэ үед Богд хаант Монгол Улсыг байгуулагдсаны дараагаар Цэвээн Жамсранов тэргүүтэй баян, сэхээтэн буриадууд монгол туургатны нэгдсэн улс байгуулах үзэл санааг дэмжих үүднээс Богд хааны урилгаар шилжин суурьшсан байна⁴.

3. 1917-1920 он. 1920-иод оны үед буриадууд дотооддоо болж байсан иргэний дайнаас дайжин Монголын хойт, зүүн хойт хилийн гарцтай, гарцгүй, ердийн хөсөг явж болох замтай замгүй газраар, өдөр шөнийн цагаар хөвөрсөн их нүүдлийнхэн эрх чөлөө, энх амгалан амьдрал эрэлхийлэн бөөнөөрөө /энэ нүүдлээр нийт 300 орчим өрх айл ирсэн/ дүрвэн орж ирсэн бөгөөд одоогийн Хэнтий аймгийн Батширээт, Дадал, Баян-Адарга, Биндэр, Дорнод аймгийн Баян-Уул, Дашбалбар, Баяндун, Цагаан овоо суманд нутаг заан өгч суулгасан⁵ ба 1924 оны БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулиар тэдгээр иргэдэд Монгол Улсын иргэний харьяаллыг өгчээ.

1910 оны эхээр овог аймгийн мөргөлдөөнөөс дайжин Туркестанаас Шинжаанаар дамжин ирсэн 3000 орчим казахууд дээр 1942 оны орчим Ховдын хязгаараар нэлээд олон казахууд нэмэгдэн орж ирсэн. Олноо өргөгдсөн Монгол улсын үед казахуудын дагаар орох өргөдлийг Богд хаан хүлээн авч, нутаг зааж өгөн, тэдгээрийн харьяаллын асуудлыг тухайн үед нааштайгаар зохицуулан шийдэж байжээ.

Олон улсын эрх зүйн хувьд ч тэр, улс гүрнүүд дүрвэгсдийн асуудлыг хэрхэн зохицуулахаа хуульчилсан эрх зүйн зохицуулалт төгс хэлбэрээр үгүй байсан тэр үед монголчуудын шийдвэрлэсэн байдлыг дүгнэж үзвэл дүрвэгсдийг хүлээн авсан байдлаараа зохих туршлагатай орон гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй юм.

² Роберт А. Рупен "XX зууны Монголчуудын түүх", УБ, 2000 он, 17 дахь тал

³ "Орос дахь Монгол угсааны улсууд", УБ, 1995 он, 15 дахь тал

⁴ Д.Дамдинжав "Монголын буриад зон" 2001 он, 31 дэх тал. УБ

⁵ Д.Дамдинжав "Монголын буриад зон" 2001 он, 34 дэх тал УБ

⁶ Төрийн Мэдээлэл сэтгүүл., 1994 он., №9, х-781. АЭ сонин, 1994, №145

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдал гэж Монгол Улсын Үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байхыг хэлнэ”⁶ гэж тодорхойлсон байдаг.

Хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудад дүрвэгсэд олноор орж ирэх нь эдийн засгийн ачааллыг ихэсгэх бөгөөд дотоодын хүн амыг хүнс тэжээл, бусад өргөн хэрэглээний бараагаар хангахад сөргөөр нөлөөлдөг. Дүрвэгсдийн хамгаалал, тусламжтай холбоотой асуудал голдуу улсуудын сувернитетийг зайлшгүй хөнддөг бөгөөд энэ нь дотоодын хууль тогтоомжийн аюулгүй байдалд ч нөлөөлдөг тал бий.

Монгол Улсын УАБ-ын үзэл баримтлалд “оршин тогтнохын аюулгүй байдал” гэж Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал хангагдсаныг хэлэх⁷ агаад тус үзэл баримтлалын 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг буюу “оршин тогтнохын аюулгүй байдалд сөргөөр нөлөө үзүүлэх гадаад хүчин зүйл”-д зааснаар: Монгол улс, түүний ард иргэдийн эсрэг алан хядах, хорлон сүйтгэх, тагнан турших үйл ажиллагаа явуулах, зохион байгуулах буюу тийнхүү үйл ажиллагаа явуулахыг өдөөн турхирах, туслах явдал юм.

Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудыг судлаад үзэхэд дүрвэгсдийн эрх зүйн зохицуулалтыг хэд хэдэн хууль тогтоомжид эрээвэр хураавар боловч ямар нэгэн байдлаар хүлээн зөвшөөрсөн байдалтай байна. Тухайлбал: Монгол улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар “.. үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харъяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол улсад орогнох эрх олгож болно”.

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай” хуулийн 6 дугаар зүйлд зааснаар “...Монгол улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд тус улсад оршин суух эрх олгож төрийн ивээлд авч болно ...гэж заасан байдаг.

Нөгөөтэйгүүр Монгол Улсын нэгдэн орсон хэд хэдэн конвенцэд дээрх эрхийг биелүүлэх үүргийг баталгаажуулсан байгаа зэргээс үзэхүл дүрвэгсдийн асуудлыг нэг мөр болгон цэгцлэх боломжтой гэж дүгнэж болохоор байна.

Мөн Монгол Улсын нэгдэн орсон 1984 оны “...эрүүдэн шүүлтийн эсрэг” Конвенцийн зүйл 3-ийн 1 дэх хэсэгт зааснаар дүрвэгсдийн эрхийн үндсийн үндэс болсон “үл буцаан шилжүүлэх” үүргийг улсуудад оноосон байдаг.

Мөн НҮБ-ын “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” 1989 оны Конвенцийн 22 зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу харгалзагч хүнтэй, хүнгүй алин боловч дүрвэгч хүүхдийг хамгаалах эрхийг хүлээн зөвшөөрсөн нь хэрэгжих бүрэн нөхцөл бүрэлдсэн гэж дүгнэж болно.

⁷ “Төрийн Мэдээлэл” сэтгүүл., 1994 №9

Монго
эдийн засгийн
“Дүрвэгсдийн
нь зүйтэй. Я
өгсөн үүргийг
хараахан бэл
Эдүгээ
хөл дээрээ
байгууллагуу
хоног өнгөр
оронгоор ха
халамжийн ү
000 хүн орос
засгийн аюул

Гэхдээ з
орохгүй байх
болзошгүй а
бэлэн байх уч

Монгол
бодлогыг хэ
байгууллагуу
холбогдсон ү
иргэдийн эрх
заасныг бари
болгон “Гадаа
үйл ажиллагаа
дүрвэгсэд бол
гаралтай хүм
судалгааны тө
байна.

Article is
policy towards
Law on refugee
Article d
Mongolia late
international law
historical lessons

Монгол Улс дүрвэгсдийг хүлээн авах цаг хугацааны хийгээд санхүү, эдийн засгийн чадавхийн хувьд бололцоо, нөхцөл сулавтар байгаа учир "Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай" Конвенцэд нэгдэхээс түр түдгэлзэх нь зүйтэй. Яагаад гэвэл, Конвенцэд нэгдэн орсон улс НҮБ-ын ДДК-ын өгсөн үүргийг шууд биелүүлэх үүрэг хариуцлага хүлээхэд Монгол улс хараахан бэлэн биш байна.

Эдүгээ Монгол Улс санхүү, эдийн засгийн хүчин чадавхийн хувьд хөл дээрээ баттай зогсож чадаагүй, олон улсын эдийн засгийн байгууллагууд болон хандивлагч орнуудын зээл тусламжинд дулдуйдан хоног өнгөрөөж байгаагийн гадна дүрвэгсдийг ажлын байр, орох оронгоор хангах боломжгүй, зах зээлийн багтаамж бага, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл тааруу, цөөхөн хүн амтай тул 100 000 хүн ороод ирсэн ч Монгол улсын оршин тогтнохын болоод эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх магадлал өндөр юм.

Гэхдээ энэ бүгд нь Дүрвэгсдийн эрх зүйн байдлын Конвенцэд нэгдэж орохгүй байх шалтаг биш бөгөөд энэ нөхцөл байдал арилсны дараа эсхүл болзошгүй асуудалд хандах утгаараа хууль, эрх зүйн хувьд дотооддоо бэлэн байх учиртай.

Монгол Улсаас гадаадын иргэдийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, төрийн захиргааны төв байгууллагуудын гадаадын иргэний эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдсон үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх чиг үүргийг "Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан 2001 оны 4 дүгээр сард ХЗДХЯ-ны дэргэд агентлаг болгон "Гадаадын иргэд, харьяатын асуудал эрхэлсэн алба"-ыг байгуулан үйл ажиллагаагаа эхлээд байгаа нь сайшаалтай бөгөөд хэтдээ энэ албыг дүрвэгсэд болон гадаадад шилжин суурьшсан, цагаачилсан монгол гаралтай хүмүүсийн хөдөлгөөн, аж байдлын асуудлыг судалдаг судалгааны төв болгон үйл ажиллагаагаа өргөжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Article is about objective need for Mongolia to carry out systematic state policy towards refugee issue in current situation of the world globalization. Law on refugee legal status is required from a point of the national security.

Article deals with historical issues of settlement of refugees in Mongolia late 19th early 20th century when regulating mechanism of international law was not being introduces yet. It also raises issues of historical lessons and ways to avoid them.